



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26-44-44, Факс: (976-11) 32-90-84,
E-mail: info@frc.mn, <http://www.frc.mn>

2023.02.28 № ЦМ-8/06 .
танай 2022.12.20 -ны № 22/12 -т

Сонгуульт гишүүдийн бүртгэлийн тухай

Танай хоршооноос зөвшөөрлийн цахим системээр ирүүлсэн гүйцэтгэх захирлын өөрчлөлт бүртгүүлэх хүсэлт, холбогдох баримт бичгийг хянаж үзэхэд гүйцэтгэх захирал Н.Алпысбайг холбогдох бүртгэлд бүртгэсэн тухай мэдэгдлийг Хорооны 2022 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 8/4029 тоот албан бичгээр хүргүүлсэн байна.

Мэдээллийн нэгдсэн санд “Малчны хөгжил” ХЗХ-ны сонгуульт гишүүдийн бүртгэл дараах байдалтай байна. Үүнд:

№	Хамаарал	Нэр	Тайлбар	
1	Тэргүүлэгчдийн зөвлөл	Дарга	Т.Ахай	бүртгэлтэй
2		Гишүүн	Х.Соронзонболд	бүртгэлтэй
3		Гишүүн	С.Серикгүл	бүртгэлтэй
4		Гишүүн	М.Бектас	бүртгэлтэй
5		Гишүүн	Х.Бердиузах	бүртгэлтэй
6	Хяналтын зөвлөл	Дарга	Д.Ербол	бүртгэлтэй
7		Гишүүн	Т.Бауыржан	бүртгэлтэй
8	Зээлийн хороо	Дарга	Н.Алпысбай	бүртгэлтэй
9		Гишүүн	К.Абилхасен	бүртгэлтэй
10		Гишүүн	Х.Саулегүл	бүртгэлтэй
11	Гүйцэтгэх захирал	Н.Алпысбай	бүртгэлтэй	
12	Нягтлан бодогч	Х.Саулегүл	бүртгэлтэй	

Мөн дээрх албан бичгээр хяналтын зөвлөлийн гишүүн Т.Айтуган нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д заасан хязгаарлалтыг зөрчиж, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.3.3-т заасан шаардлагыг хангахгүй байгаа тул хоршооны сонгуульт ажлыг хаших боломжгүй бөгөөд хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гишүүнийг бүх гишүүдийн хурлаар хэлэлцэн сонгож, өөрчлөлтийг ажлын 10 хоногийн дотор Хороонд бүртгүүлэх шаардлагатайг мэдэгдсэн боловч ирүүлээгүй байна.

Иймд шинэ сонгуульт гишүүний өөрчлөлт бүртгүүлэх мэдэгдлийг Хорооны 2018 оны 245 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах нөхцөл, шаардлага”-ын 8.2-т заасан баримт бичгийн хамт ирүүлэх шаардлагатайг анхаарна уу.

